



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/105

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1.а заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоол, Сангийн сайдын 239-р тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2016 онд урлаг, спорт, сурлагын өндөр амжилт гаргасан Орхон аймгийн уран бүтээлч, тамирчин, сурагчид, тэднийг бэлтгэсэн багш, дасгалжуулагчдын шагналыг гардуулах үйл ажиллагаанд зарцуулах зардлыг баталсугай.

2.Үйл ажиллагаанд шаардагдах зардал болох 1000000 /Нэг сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын “Соёл, спорт, хүүхэд залуучууд, олон нийтийн арга хэмжээг жилийн туршид зохион байгуулах” арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ